



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй  
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3, 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 50 (тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 223,570,000 (хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга) ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн)-т, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Сэндли ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 50 (тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 156,570,000 (нэг зуун тавин зургаан сая таван зуун далан мянга) ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 67,000,000 (жаран долоон сая) ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 150 (нэг зуун тавь) төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Сэндли ББСБ” ХХК (Б.Одгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөлөөр анхдагч зах зээлд худалдахыг “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК (Б.Өлзийбаяр), “Райнос инвестмент ҮЦК” ХХК (Бэ Санг Хёк)-д тус тус зөвшөөрч, олон нийтэд танилцуулах, сурталчлах болон хувьцааны захиалгыг эхлүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг 100 (нэг зуу) хувь худалдсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Сэндли ББСБ” ХХК (Б.Одгэрэл)-д мэдэгдсүгэй.

6. Санхүүгийн зохицуулах хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д үүрэг болгосугай.


7. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК (Б.Өлзийбаяр), “Райнос инвестмент ҮЦК” ХХК (Бэ Санг Хёк)-д анхааруулсугай.

9. “Сэндли ББСБ” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Сэндли ББСБ” ХХК (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

10. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК (Б.Өлзийбаяр), “Райнос инвестмент ҮЦК” ХХК (Бэ Санг Хёк), “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН (Д.Дүгэржав), “Шонхор Аудит” ХХК (Д.Шийрэв), “Гэрэгэ Эстимэйт” ХХК (Д.Ганбаатар)-д тус тус анхааруулсугай.

11. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2022 оны 08 дугаар сарын 10-ны  
өдрийн 413 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо ширхэг
1	“Монголын финтек групп” ХК		126,141,700
2	“Сэндли эмплойе” ХХК		20,000,000
3	Баттулга Наранбат		8,000,000
4	“Радикс технологи” ХХК		1,714,200
5	Батдорж Нямжаргал		285,700
6	Зургаа Цолмон		107,100
7	Чойжоо Дашсүрэн		71,400
8	Лхагважав Нарантуяа		71,400
9	Охиндоо Нямдэлэг		71,400
10	Ганхуяг Саруул-Од		71,400
11	Гантөмөр Гантуяа		35,700
	<b>Нийт дүн</b>		<b>156,570,000</b>